

“ГЕО ТЕХ ИМПЕКС” ХХК-д

~~хариу хүргүүлэх тухай~~

2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 20/62 тоот тодруулга авах тухай албан бичигтэй танилцан, дараах хариуг хүргүүлж байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-иас зарласан ЭМГЛ/202001010 зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх хугацаа буюу нөөцийн тооцооны тайланг боловсруулах ажлыг захиалагчийн зүгээс 30 хоногт багтаан гүйцэтгэх боломжтой гэж үзсэн. Нөөц бүртгүүлэхтэй холбоотой шинжээч томилогдох хугацаа, шүүмж өгөх хугацаа, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх зэрэг хугацаануудыг урьдчилан нарийн тооцоолох боломжгүй бөгөөд “хамгийн сайн үнэлэгдсэн” тендер ирүүлсэн этгээдтэй гэрээ байгуулах явцад дээрх хугацааг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Хүндэтгэсэн,

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

